

Аудитын код: САГ-2018/8/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaa@audit.gov.mn

Аудитор Б.Сэржмядаг
Утас: 261740 Цахим хаяг: serjmyadag@audit.gov.mn

Аккурэйт финанс аудит ХХК
Утас: 70133743 Цахим хаяг: acc.fin.audit@gmail.com

Захирал: Ж.Оюунбилэг
Утас: 99995143 Цахим хаяг: oyunbileg2003@gmail.com

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Санхүүгийн тайлангийн талаар.....	4
2.9.2	Дансны авлагын талаар.....	4
2.9.3	Зардлын дансны талаар.....	4
2.9.4	Хандгайт-Төмөртэй чиглэлийн төмөр замын талаар.....	4
2.9.5	Төслийн ажилчдын талаар.....	5
	Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна.....	5
2.9.6	БНХАУ-ын Экспорт-импортын банкны зээлийн талаар.....	5
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	6
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	6
2.15	Хязгаарлалттай санал дүгнэлт	7
3	Менежментийн захидал.....	8
3.1	Санхүүгийн тайлан талаар	9
3.2	Зардлын талаар	10
3.3	Хандгайт-Төмөртэй чиглэлийн төмөр замын талаар	11
3.4	Төслийн ажилчдын талаар	12
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	14
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ЦЭНГЭЛ ТАНАА

2018.03.28 № 06/851
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Монголын төмөр зам ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын төмөр зам ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

10.10.2018\Bichir\Khered\Yawsan_Bichir\2018\0328S&G10.Docx

01	ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ
-----------	--

Аудитын гол асуудал

- Монгол улс болон БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан “Зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн дүнд “Төмөр замын хөдлөх бүрэлдхүүний паркийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд 2010 онд 35.7 сая ам.долларын хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаж, ашиглаж байгаа боловч Сангийн яамтай дамжуулан зээлдүүлэх зээлийн гэрээ хийгээгүй, хуримтлагдсан хүүгийн өглөг 9,219.9 сая төгрөгт хүрсэн,
- Хандгайт-Төмөртэй чиглэлийн төмөр замаар хувийн компаний тээвэр хийж 162.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан,
- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ажил зогссон байхад 310.7 сая төгрөгийн цалингийн зардал гарсан,
- Хугацаа хэтэрсэн, тооцоо нийлж баталгаажуулаагүй 54.8 сая төгрөгийн дансны авлага зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн эрх үүрэг, иж бүрэн байх, үнэлгээ, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Монголын төмөр зам ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд Аккурэйт финанс аудит ХХК гэрээгээр аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


Монголын төмөр зам ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /НББОУС/, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Монголын төмөр зам ТӨХК-ийн удирдлага нь санхүүгийн тайлангаа НББОУС, СТОУС түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрөөс 3 дугаар сарын 12-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэхээр төлөвлөн Аккурэйт финанс аудит ХХК-ийн аудитор Ж.Оюунбилэг, аудитор Ч.Бат-Эрдэнэ, аудитор Д.Сайнбаяр, аудитор Л.Баярмаа, аудиторовын туслах А.Алтанчимэг нар хэрэгжүүлж ажиллав. /ТАБ-СТА-А-9/

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангаа 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдөр 01/263 тоот албан бичгээр Аккурэйт финанс аудит ХХК-д ирүүлсэн байна.



Аккурэйт финанс аудит ХХК-ийн аудитын баг аудитын дуусгавар болсон тайланг 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдөр Монголын төмөр зам ТӨХК-ийн удирдлагад танилцуулав.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монголын төмөр зам ТӨХК-ийн удирдлага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төмөр замын тээврийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Монголын төмөр зам ТӨХК нь Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 82 дугаар тогтоолыг үндэслэн Төрийн өмчийн хорооны 2008 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 189 дүгээр тогтоолоор байгуулагдсан.

Монголын төмөр зам ТӨХК нь:

- Төмөр замын суурь бүтэц барих, ашиглах,
- Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх,
- Төмөр замын суурь, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах,
- Улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар төмөр замын салбарт үүсэн бий болсон хөрөнгийг эзэмшиж, ашиглах гэсэн үндсэн 4 чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Монголын төмөр зам ТӨХК-ийн удирдлага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Концессын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын багц хуулиуд болон холбогдох бусад хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Монголын төмөр зам ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн


Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашигласан болно. Аудитаар Монголын төмөр зам ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын 48 горим, 16 сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн онцлогт тохируулан боловсруулж 2016 онд компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан байна.

Монголын төмөр зам ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага, мэдээллийн технологийн

/ТАБ-СТА-В-2/



Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, боловсруулах үйл ажиллагааг НББОУС-тай нийцсэн Даймонд санхүүгийн програмыг ашиглан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Монголын төмөр зам ТӨХК-ийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна. Мөн Монголын төмөр зам ТӨХК-ийн 2015, 2016 оны санхүү эдийн засаг, үндсэн үйл ажиллагаанд 2017 оны 6 дугаар сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохих удирдамжийн дагуу шалгалт хийсэн байна.

2.6 Орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2017 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолоор батлаж илчит тэрэг, вагон түрээс, тээвэрлэлтээс нийт 9,589.9 сая төгрөгийн орлого олж удирдлага болон үйл ажиллагааны зардалд 8,932.1 сая төгрөгийн зардал гаргаж 657.0 сая төгрөгийн ашигтай ажиллагаар төлөвлөсөн.

Тайлант онд илчит тэрэг, вагон түрээс, тээвэрлэлтээс 6,159.9 сая төгрөг, хүүгийн орлого 1,231.2 сая төгрөг, нийт 7,391,0 орлого олж удирдлага болон үйл ажиллагааны зардалд 7,202.4 сая төгрөгийн зардал гаргажээ.

Орлогын төлөвлөгөө Хандгайт-Төмөртэй чиглэлийн тээвэрлэлтийн орлого 2,695.5 сая төгрөгөөр, түрээсийн орлого 734.4 сая төгрөгөөр тасарсан нь нөлөөлжээ.

2.7 Шилэн дансны мэдээлэл


Тус компани нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах тушаал шийдвэрүүдийг батлан дагаж мөрдөн ажиллаж ирсэн байна. Үүнд:

2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/64 тоот “Журам батлах тухай”, 2016 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/02 тоот “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” гүйцэтгэх захирлын тушаалаар шилэн дансны мэдээлэл бэлтгэх, хариуцах, тайлагнах ажилтнуудыг томилон мэдээ тайланг www.shilendans.gov.mn нэгдсэн сайтад хувиарын дагуу байршуулж ажилласан байна. Тайлант онд Монголын төмөр зам ТӨХК нь цахим сандаа 6 төрлийн нийт 61 мэдээллийг байршуулснаас, 6 мэдээллийг хугацаа хожимдуулсан буюу засвар оруулан байршуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Монголын төмөр зам ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний галаад, дотоод орны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээнд 12 горим багцаж мэдэгдлүүдийн хүрээнд данс тус бүрээр 48 нарийвчилсан горим сорил гүйцэтгэж баримтжуулав. /ТАБ-СТА-В-3/



2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад доорхи материаллаг бус хэмжээтэй алдаа зөрчилүүд нь санхүүгийн тайлангийн эрх үүрэг, тохиолдсон байх, үнэлгээ, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байсан ба холбогдох хуулийн заалтуудыг зөрчсөн байна.

2.9.1 Санхүүгийн тайлангийн талаар

Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн болох санхүүгийн тайлангийн тодруулгыг мянган төгрөгөөр илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын 1.4-т заасан "Санхүүгийн тайлан, тодруулгын үзүүлэлтийг төгрөг, мөнгөөр илэрхийлнэ." гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ыг мөрдөн ажиллах талаар зөвлөмж өгч залруулсан болно.

2.9.2 Дансны авлагын талаар

Тайлант онд тооцоо нийлсэн акт үйлдээгүй төлөгдөх хугацаа хэтэрсэн 54.8 сая төгрөгийн дансны авлага байна. Үүнээс 51.4 сая төгрөг нь Төрийн өмчийн хорооноос (хуучнаар) 2012 оны 6 сард авах ёстой байсан авлага, 3.4 сая төгрөг нь Л.Цэнгэлийн сургалтын төлбөрийн үлдэгдэл байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, ТУЗ-д танилцуулж тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулан авлагыг барагдуулах талаар албан шаардлага өгсөн.


2.9.3 Зардлын дансны талаар

Нийт 23.2 сая төгрөгийг зардлын дансдад буруу ангилан тайлагнасан. Үүнээс 16.4 сая төгрөг нь татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.4-т заасан үнэн зөв байх гэсэн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зардлын дансыг зөв ангилан, Нягтлан бодох бүртгэлийн тухай, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох заавар, журмуудыг мөрдөж ажиллах,

2.9.4 Хандгайт-Төмөртэй чиглэлийн төмөр замын талаар

Хандгайт-Төмөртэй чиглэлийн 33.4 км төмөр замыг барих-шилжүүлэх төслийг Засгийн газрын 2018 оны тогтоолоор цуцалсан. Гэвч тухайн чиглэлийн төмөр замаар Монголын төмөр зам ТӨХК 2016 оны 05 дугаар сараас эхлэн тээвэрлэлт хийж эхэлжээ.



2017 онд 2.0 сая тн хүдэр тээвэрлэхээр төлөвлөснөөс 0.7 сая тонн хүдэр тээвэрлэж 1,960.6 сая төгрөгийн зардал гарган, 1,798.1 сая төгрөгийн орлого олж 162.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Ганцхан компанийн ачааг тээвэрлэхийн тулд алдагдал хүлээж байгаа нь тус компанийн санхүүгийн тайлангийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Шийдвэрлэсэн нь: Өрийн удирдлагын тухай хуулийн 5.1.3-т “өр үүсэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах”, Компанийн дүрмийн 2.1-т “Компанийн үндсэн зорилт нь иргэн аж ахуйн нэгж, байгууллагад төмөр замын тээврийн үйлчилгээ үзүүлж, ашгийн төлөө ажиллахад оршино” гэж заасныг мөрдөж ажиллах,

2.9.5 Төслийн ажилчдын талаар

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ажил 2015 оны 2 дугаар сараас Хөгжлийн банкны санхүүжилт зогссонтой холбоотойгоор зогсонги байдалд орсон. Улмаар төслийг дуусгавар болгох хэлэлцээр 2016 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр эцэслэн байгуулагдсан. Замын ажил зогссон ч төслийн ажилтнууд одоог хүртэл ажилласаар байгаа ба 2017 онд төслийн ажилчдын жилийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нийт 310.7 сая төгрөг болсон байна. Энэ нь компанийн санхүүгийн тайлангийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж үргүй зардал гарах магадлалтай байна.

Шийдвэрлэсэн нь: ТУЗ болон гүйцэтгэх удирдлага энэ талаар арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна.

2.9.6 БНХАУ-ын Экспорт-импортын банкны зээлийн талаар

2010 онд БНХАУ-ын Экспорт-импортын банкны зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 35.7 сая ам.долларын хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаж үйл ажиллагаандаа ашиглаж байгаа боловч одоог хүртэл засгийн газартай дамжуулан зээлдүүлэх гэрээ хийгдээгүй байна. Зээл авсанаас хойш зээлийн эргэн төлөлт хийгдээгүй одоогоор зээлийн хуримтлагдсан хүүгийн өглөг 9,219.9 сая төгрөг болсон. Зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөөгүйгээс үүсэх алданги нэмэгдсээр байгааг анхаарах шаардлагатай байна.

Шийдвэрлэсэн нь: Өрийн удирдлагын тухай хуулийн 30.2-т “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор дамжуулан зээлдүүлэх тохиолдолд тухайн салбар эсхүл орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь дэд зээлдэгчийн үүргийг гүйцэтгэх бөгөөд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон дэд зээлдэгч, эцсийн зээлдэгчийн хооронд гурвалсан гэрээ байгуулна”, Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалын хавсралтын 8.3.1-т “төсөл, арга хэмжээний гэрээ, хэлэлцээр, үйл ажиллагаа болон худалдан авалтын төлөвлөгөө, тэдгээрийн хэрэгжилт, гүйцэтгэл, тайлагналтыг олон нийтэд тогтсон хугацаанд мэдээлэх” гэж заасны дагуу “Төмөр замын хөдлөх бүрэлдхүүний паркийг нэмэгдүүлэх төсөл”-ийн зээлийг дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулах,

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 сарын 27-ны өдрийн 244 тоот тогтоол, 2017 оны Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн дагуу 421.6 сая төгрөгийн өртөг бүхий Ухаа худаг-Гашуун сухайт чиглэлийн замын суурь бүтэц болон бусад эргэлтийн хөрөнгийг бараа материалын дансанд орлого авсан байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Хандгайт-Төмөртэй чиглэлийн төмөр замын талаар, НӨАТ-ын буцаан авалтын талаар, “Шинэ төмөр зам” төслийн бүртгээгүй хөрөнгө өр төлбөрийн талаар цаашид гүйцээн мөшгин шалгаж тулган баталгаажуулж ажиллах шаардлагатай. Үүнд:

- Хандгайт-Төмөртэй чиглэлийн 33.4км төмөр замыг ачиж буулгах терминалын хамт барих-шилжүүлэх төслийг (Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралтын 5 дахь заалт) цуцалснаар, МТЗ ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлд бүртгэх шаардлагагүй болсон. Одоогийн байдлаар дээрхи чиглэлийн төмөр замын 183,608.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал нь ЗТХЯамны хөрөнгө оруулалтын тайлан тэнцэлд тусгагдсан бөгөөд тус замаар МТЗ ТӨХК тээвэрлэлт хийж байна.
- Татварын үлдэгдэл баталгаажуулах шалгалтаар тус компанийн 18,500.0 сая төгрөгийн НӨАТ-ын буцаалтыг хүчингүй болгосон. Компани татварын актыг зөвшөөрөхгүй асуудлаа шийдвэрлүүлэхээр шүүхэд хандсан байна. Захиргааны хэргийн анхан шатны шүүх татварын байцаагчийн актыг хүчингүй болгож, давж заалдах шатны шүүхээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна. Одоогоор дээд шүүхийн хяналтанд байна.
- “Шинэ төмөр замын төсөл” -ийн үндсэн санхүүжилт зогссонтой холбогдон гүйцэтгэгчиддээ ажил гүйцэтгэлийн төлбөрийг төлж чадахгүй болсон. Харилцагчид ажлын гүйцэтгэлийг дүгнэсэн акт, ажлын тайлангаа үндсэн баримт болгож төлбөр нэхэмжилж байгаа боловч компани өглөгөөр бүртгээгүй байна. Бүртгэгдээгүй шүүхийн шатанд байгаа өглөг, алданги нийлээд 19,609.0 сая төгрөг байна.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ


Монголын төмөр зам ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 9,771.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн ба үүнээс 185.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 9,585.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Конфиденсе аудит ХХК 10 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 60 хувийг хэрэгжүүлж, 40 хувийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлохдоо хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн өсөлттэй холбогдуулан цэвэр хөрөнгийн дүнгээс сонгосон болно.



Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн цэвэр өөрийн хөрөнгийн дүнгийн 0.1 хувь буюу 479.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 Хязгаарлалттай санал дүгнэлт

Бид Монголын төмөр зам ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дээрхи алдаа, зөрчлийг эс тооцвол Монголын төмөр зам ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн, бодитой, шударга материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 4 хуудас, байгууллагын санхүүгийн тайлан, хавсралтууд 14 хуудас, байгууллагын санал 3 хуудсыг тус тус хавсаргав.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Аккурэйт финанс аудит ХХК аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Монголын төмөр зам ТӨХК-ийн удирдлагад зориулан бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын Олон Улсын Стандарт болон аудитын дүн дүгнэлтээс гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн аудитын горим сорил нь санхүүгийн тайлан, тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад зориулагдан гарсан болно.

Тиймээс аудитын зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Монголын төмөр зам ТӨХК-ийн захирал Б.Цэнгэл, ерөнхий нягтлан бодогч Д.Даваадорж болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

Аудитын ажиглалт

Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн болох санхүүгийн тайлангийн тодруулгыг мянган төгрөгөөр илэрхийлсэн байна. Энэ нь НББүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын 1.4-т "Санхүүгийн тайлан, тодруулгын үзүүлэлтийг төгрөг, мөнгөөр илэрхийлнэ." гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн заалт зөрчигдөж, санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх үүрэг батламжийн мэдэгдлүүд зөрчигдөх,

Аудитын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Сангийн сайдын 2017 оны 12 сарын 14-ний өдрийн 361 дугаар тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ыг мөрдөж ажиллах,

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 05 сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,

Төсвийн захирагчийн хариу

Аудитын зөвлөмжийг удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.



3.2 ЗАРДЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №2

Аудитын ажиглалт

Нийт 23.2 сая төгрөгийг зардлын дансад буруу ангилан тайлагнасан. Үүнээс 16.4 сая төгрөг нь татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.4-т заасан үнэн зөв байх гэсэн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэнтэй нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх,

Аудитын зөвлөмж

Зардлын дансыг зөв ангилан, Нягтлан бодох бүртгэлийн тухай, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох заавар, журмуудыг мөрдөн ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 05 сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,

Төсвийн захирагчийн хариу

Аудитын зөвлөмжийг удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

**3.3 Хандгайт-Төмөртэй чиглэлийн төмөр
ЗАМЫН ТАЛААР****Тэргүүлэх ач холбогдол №3****Аудитын ажиглалт**

Хандгайт-Төмөртэй чиглэлийн 33.4 км төмөр замыг ачиж буулгах терминалын хамт барих-шилжүүлэх төслийг Засгийн газрын 2018 оны 01 дүгээр 04-ний өдрийн 6 тоот тогтоолоор цуцалсан. Гэвч тухайн чиглэлийн төмөр замаар Монголын төмөр зам ТӨХК 2016 оны 05 дугаар сараас эхлэн тээвэрлэлт хийж эхэлжээ.

2017 онд 2.0 сая тн хүдэр тээвэрлэхээр төлөвлөснөөс 0.7 сая тонн хүдэр тээвэрлэж 1,960.6 сая төгрөгийн зардал гарган, 1,798.1 сая төгрөгийн орлого олж 162.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Ганцхан компанийн ачааг тээвэрлэхийн тул алдагдал хүлээж байгаа нь тус компанийн санхүүгийн тайлангийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн орлого зардал уялдах зарчим алдагдсан ба компани үргүй зардал гаргаж байх магадлал байна.

Аудитын зөвлөмж

Өрийн удирдлагын тухай хуулийн 5.1.3-т “өр үүсэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах”, Компанийн дүрмийн 2.1-т “Компанийн үндсэн зорилт нь иргэн аж ахуйн нэгж, байгууллагад төмөр замын тээврийн үйлчилгээ үзүүлж, ашгийн төлөө ажиллахад оршино” гэж заасныг мөрдөж ажиллах,

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 05 сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,

Төсвийн захирагчийн хариу

Аудитын зөвлөмжийг удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.4 Төслийн ажилчдын талаар**Тэргүүлэх ач холбогдол №4****Аудитын ажиглалт**

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ажил 2015 оны 2 дугаар сараас Хөгжлийн банкны санхүүжилт зогссонтой холбоотойгоор зогсонги байдалд орсон байна. Улмаар төслийг 2016 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөр дуусгавар болгон цуцалжээ. Замын ажил зогссон ч төслийн ажилтнууд одоог хүртэл ажилласаар байгаа ба 2017 онд төслийн ажилчдын жилийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нийт 310.7 сая төгрөг болсон байна. Энэ нь компанийн санхүүгийн тайлангийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж үргүй зардал гарах магадлалтай байна

Эрсдэлүүд

Компани үргүй зардал гаргаж байх магадлал байна.

Аудитын зөвлөмж

ТУЗ болон гүйцэтгэх удирдлага энэ талаар арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 05 сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,

Төсвийн захирагчийн хариу

Аудитын зөвлөмжийг удирдлага хүлээн зөвшөөрсөн болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	12,762,884,570.39	9,633,863,513.06
1.1.2	Дансны авлага	1,398,713,346.23	1,373,461,583.39
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	9,567,014,412.16	10,325,642,210.08
1.1.4	Бусад авлага	39,603,956.93	45,612,735.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	38,491,270,991.32	456,063,084,550.59
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	362,487,055,489.26	28,609,701,172.28
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	2,835,708,700.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	424,746,542,766.29	508,887,074,464.40
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	62,427,601,687.62	66,105,026,727.31
1.2.2	Биет бус хөрөнгө	65,678,882.12	64,641,316.57
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	62,493,280,569.74	66,169,668,043.88
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	487,239,823,336.03	575,056,742,508.28
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	53,178,143.99	487,279.98
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	1,984,625,554.07	108,794,492.36
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	8,162,089,721.40	9,219,898,829.01
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	10,199,893,419.46	9,329,180,601.35
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	88,856,703,084.80	86,629,512,300.80
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	88,856,703,084.80	86,629,512,300.80
2.2	Өр төлбөрийн нийт дүн	99,056,596,504.26	95,958,692,902.15
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: -төрийн өмч	20,727,658,514.60	20,727,658,514.60
2.3.2	-хувийн өмч	-	-
2.3.3	-хувьцаат өмч	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	402,087,474,920.79	510,882,250,207.67
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(34,631,906,603.62)	(58,611,965,116.14)
2.3.11	Эздийн өмчийн дүн	388,183,226,831.77	479,098,050,606.13
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	487,239,823,336.03	575,056,742,508.28

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,138,079,056.56	1,798,095,009.72
2	Борлуулалтын өртөг	2,517,041,591.89	1,960,611,484.03
3	Нийт ашиг (алдагдал)	621,037,464.67	(162,516,474.31)
4	Түрээсийн орлого	674,609,220.82	4,361,792,763.87
5	Хүүгийн орлого	1,226,521,264.12	1,231,239,133.76
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,112,157,457.11	3,704,898,843.38
11	Санхүүгийн зардал	1,352,422,651.91	1,521,062,393.07
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(19,507,124,652.60)	2,342,606,979.07
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	37,917,349.79	(35,707,102.75)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(20,411,619,462.22)	2,511,454,063.19
19	Орлогын татварын зардал	122,652,126.41	123,123,913.31
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(20,534,271,588.63)	2,388,330,149.88
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(20,534,271,588.63)	2,388,330,149.88
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	(20,534,271,588.63)	2,388,330,149.88
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	(20,534,271,588.63)	2,388,330,149.88

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан дүн	Нийт дүн
1	2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60	386,941,632,439.49	(14,463,401,703.81)	393,205,889,250.28
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	365,766,670.12	365,766,670.12
3	Залруулсан үлдэгдэл	20,727,658,514.60	386,941,632,439.49	(14,097,635,033.69)	393,571,655,920.40
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(20,534,271,588.63)	(20,534,271,588.63)
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
6	Өмчид гаргасан өөрчлөлт	-	15,145,842,500.00	-	15,145,842,500.00
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
9	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60	402,087,474,939.49	(34,631,906,622.32)	388,183,226,831.77
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	20,727,658,514.60	402,087,474,939.49	(34,631,906,622.32)	388,183,226,831.77
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	2,388,330,149.88	2,388,330,149.88
13	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
14	Өмчид гаргасан өөрчлөлт	-	114,894,881,268.18	(26,368,388,643.70)	88,526,492,624.48
15	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
17	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60	516,982,356,207.67	(58,611,965,116.14)	479,098,049,606.13

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ХЯЗГААРЛАЛТАЙ
 САНАЛ ДҮГНЭЛТ**

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	3,970,300,817.26	5,911,121,991.04
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	3,960,624,160.17	5,874,694,355.43
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,753,461.00	3,711,337.00
	Буцаан авсан албан татвар	-	-
	Бусад мөнгөн орлого	7,923,196.09	32,716,298.61
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,231,395,651.51	9,751,123,314.18
	Ажиллагчдад төлсөн	1,908,764,888.00	2,200,932,798.18
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	456,133,076.68	526,874,958.25
	Бараа материал худалдан авахад төлсөн	222,539,172.12	181,019,601.22
	Ашиглалтын зардалд төлсөн	506,946,695.09	22,298,620.00
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	100,351,809.35	2,587,067,594.54
	Хүүний төлбөрт төлсөн	-	257,110,445.42
	Татварын байгууллагад төлсөн	292,407,731.03	3,403,230,861.64
	Даатгалын төлбөрт төлсөн	1,034,100.00	-
	Бусад мөнгөн зарлага	1,743,218,179.24	572,588,434.93
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,261,094,834.25)	(3,840,001,323.14)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,226,521,264.12	801,682,972.95
	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө боруулсаны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
	Хүлээн авсан хүүний орлого	1,226,521,264.12	801,682,972.95
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	15,680,730,795.72	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	15,680,730,795.72	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(14,454,209,531.60)	801,682,972.95
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	14,338,254,461.75	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	14,338,254,461.75	-
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	-
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	-	-
	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	14,338,254,461.75	-
4	Валютын ханшийн зөрүү	375,537,443.88	(90,702,707.14)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,001,512,460.22)	3,129,021,057.33
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,764,397,030.61	12,762,884,570.39
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,762,884,570.39	9,633,863,513.06

01
 ТӨМӨР ЗАМ ТӨХК-ИЙН АУДИТ
 САНАЛ ДҮГНЭЛТ